



ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,  
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД  
Ж.БАТСУУРЬ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛТ**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatkhural@parliament.mn  
http://www.parliament.mn

2025.03.11 № 11

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн  
талаар

Улсын Их Хурлын даргын 2024 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн 114 дүгээр захирамжаар Боловсролын ерөнхий хуулийн хэрэгжилттэй танилцах, бүх шатны сургуулийн багшийн хомсдолыг бууруулах, үнэлэмжийг дээшлүүлэх болон төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулах асуудлыг судалж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт "Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ", Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын "Хүний хөгжил" зорилтын хүрээнд "Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцөөр хангана", Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн "Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ" гэсэн зорилтын 2.1.7-д "Багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг бодитой болгож, нийгмийн баталгааг хангана" гэж тус тус заасан.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн, бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултыг Танд тавьж байна. Үүнд:

1. Орон сууцны ипотекийн зээл авсан иргэдийн тоо, тэдгээрээс хэд нь төрийн албан хаагч, тэр дундаа ерөнхий боловсролын сургуулийн багш, цэцэрлэгийн багш хамрагдсаныг сүүлийн 10 жилээр;

2. Орон сууцны ипотекийн зээл авсан багш нарын эргэн төлөлтийн мэдээлэл (дундаж нас, хүйс, барьцаа хөрөнгийн хэмжээ, багшаар ажилласан жил) болон сар бүрийн тогтмол төлөлтийн мөнгөн дүнгийн мэдээлэл;

2025000913

3. Монгол Улсын хэмжээнд 2024 оны 08 дугаар сарын байдлаар ерөнхий боловсролын сургуульд 4200 багшийн дутагдал үүссэн бөгөөд түүнийг багасгах, багшлах хүний нөөцийг нэмэгдүүлэх, тэдгээрийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд орон сууцны дэмжлэг үзүүлэх, ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн багш нарыг түлхүү хамруулах талаар танай яамнаас ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа талаарх мэдээллийг тус тус ирүүлнэ үү.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн;

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ж.ГАЛБАДРАХ

2025000013